



**НИЙСЛЭЛИЙН
АГААРЫН БОХИРДОЛТОЙ ТЭМЦЭХ ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2021 оны 05 сарын 14 өдөр

Дугаар A/36

Улаанбаатар хот


Ажлын цагийн хуваарьт
зохицуулалт хийх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.4.18, 16.5.1 дэх заалт, Нийслэлийн Засаг даргын 2021 оны “Нийслэлийн төр, захиргааны байгууллагуудын ажлын цагийн хуваарьт зохицуулалт хийх тухай” А/362 дугаар захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн авто замын ачааллыг бууруулах зорилгоор нийслэлийн төр, захиргааны байгууллагуудын ажил эхлэх цагт зохицуулалт хийсэнтэй холбогдуулан байгууллагын ажил эхлэх цагийг 2021 оны 05 дугаар сарын 17-ны өдрөөс 08 дугаар сарын 31-ний өдрийн хооронд 08:00 цаг, бусад хугацаанд ажил эхлэх цагийг 09:00 цаг байхаар тогтоосугай.

2. Энэхүү тушаалын хэрэгжилтийг хангаж, биелэлтэд нь хяналт тавьж ажиллахыг Захиргааны хэлтэс (Ж.Балжинням), Хүний нөөц, хуулийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн (Б.Орхонбайгаль)-т үүрэг болгосугай.

ДАРГЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ



Б.ПҮРЭВСҮРЭН

1150500066